



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг тогтоох, хөнгөлөх, чөлөөлөх, төлөх, хураах болон түүнийг тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль тогтоомж

2.1.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль тогтоомж нь Татварын ерөнхий хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Улсын тэмдэгтийн хураамж

3.1.Төрийн эрх бүхий байгууллагаас энэ хуульд заасан үйлчилгээ үзүүлсний төлөө иргэн, хуулийн этгээдийн төлж байгаа мөнгөн хөрөнгийг улсын тэмдэгтийн хураамж /цаашид "тэмдэгтийн хураамж" гэх/ гэнэ.

3.2./Энэ хэсгийг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

4 дүгээр зүйл.Тэмдэгтийн хураамж төлөгч

4.1.Тэмдэгтийн хураамж төлөх үйлчилгээгээр үйлчлүүлж байгаа дараахь этгээд тэмдэгтийн хураамж төлөгч байна:

4.1.1.Монгол Улсын иргэн;

4.1.2.гадаадын иргэн, харьяалалгүй хүн;

4.1.3.төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, түүний салбар, төлөөлөгчийн газар, улс төрийн нам, хөдөлгөөн, сан, шашны байгууллага;

4.1.4.гадаад улс дахь Монгол Улсын элчин сайдын яам, консулын газраар дамжуулан үйлчилгээ авч байгаа иргэн, хуулийн этгээд.

5 дугаар зүйл.Тэмдэгтийн хураамж хураах үйлчилгээний төрөл

5.1.Тэмдэгтийн хураамжийг дор дурдсан үйлчилгээнд хураана:

5.1.1.шүүхээс эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх;

5.1.2.арбитрын ажиллагаанд шүүх оролцох;

5.1.3.нотариатын үйлчилгээ үзүүлэх;

5.1.4.иргэний бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх;

5.1.5.консулын үйлчилгээ үзүүлэх;

5.1.6.тээврийн болон өөрөө явагч хэрэгслийг бүртгэх, жолоодох зөвшөөрөл олгох;

5.1.7.Хувийн хамгаалалтын тухай хуулийн 6.1-д заасан хувийн хамгаалалт-эрхлэх тусгай зөвшөөрөл олгох;-
/Энэ заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./

5.1.8.сонин, сэтгүүл, радио, телевизийг бүртгэх;

- 9.1.13.баримт бичигт зурсан гарын үсэг гэрчлэхэд 2 500 төгрөг;
- 9.1.14.гэрчлэгдсэн баримт бичгийн хуулбарыг гэрчлэхэд хуудас тутмаас 110 төгрөг;
- 9.1.15.үйлчлүүлэгчийн хүсэлтээр үндсэн материалыг шалгахад 4 400 төгрөг;
- 9.1.16.өв залгамжлах эрх, гэрээслэл гэрчлэхэд 1 100 төгрөг;
- 9.1.17.гэр бүлийн гишүүдийн дундаа хамтран болон дундаа хэсгээр өмчлөх эрхийг гэрчлэхэд 550 төгрөг;
- 9.1.18.өвлүүлэгчийн нөхөр, эхнэр, хүүхэд, эцэг, эхээс бусад хүнд өв залгамжлах эрхийн гэрчилгээ олгоход 10 000 төгрөг;
- 9.1.19.үнэт цаас өмчлөх эрхийн гэрчилгээ гэрчлэхэд 5 000 төгрөг;
- 9.1.20.хууль тогтоомжид заасан бусад үйлчилгээ үзүүлэхэд үнийн дүнгийн 1.2 хувь.
- 9.1.21.энэ хуулийн 9.1.2-9.1.5-д зааснаас бусад гэрээ, хэлцлийг гэрчлэхэд үнийн дүнгийн 1 000 000 хүртэл төгрөгөөс 0.02 хувь, 1 000 000 төгрөгөөс давсан дүнгээс 0.01 хувиар хураах.
- 9.2.Гэрээ, хэлцэлд өөрөөр заагаагүй бол тэмдэгтийн хураамжийг хэлэлцэн тохирогч талууд тэнцүү хувааж төлнө.

10 дугаар зүйл.Иргэний улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэхэд хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

[/Энэ зүйлийн гарчигт 2018 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

~~10.1./Энэ хэсгийг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

~~10.2./Энэ хэсгийг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

10.3.Монгол Улсын иргэний үнэмлэх /цаашид "иргэний үнэмлэх" гэх/ олгох, түүнд тэмдэглэл хийхэд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

10.3.1.иргэний үнэмлэх олгоход 3 300 төгрөг;

[/Энэ заалт ад 2011 оны 6 дугаар сарын 9-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

~~10.3.2./Энэ заалтыг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

10.3.3.иргэний үнэмлэхийг 25, 45 настай иргэнд сольж олгоход 3 300 төгрөг;

10.3.4.иргэний үнэмлэхэд иргэний оршин суугаа газрын хаягийн өөрчлөлт хийхэд 1000 төгрөг;

[/Энэ заалт ад 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

~~10.3.5.оршин суух тодорхой хаяггүй Монгол Улсын харьяат иргэнд цагдаагийн байгууллагын тодорхойлолтыг үндэслэн тухайн оршин суугаа нутаг дэвсгэрийн сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар иргэний үнэмлэх олгоход 3 300 төгрөг.~~

[/Энэ заалтыг 2018 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

10.4.Гадаадад зорчих эрхийн бүртгэлд бүртгэхэд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

10.4.1.үндэсний энгийн гадаад паспорт олгоход 5 000 төгрөг;

[/Энэ заалт ад 2018 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

~~10.4.2.эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчийн хамт түр хугацаагаар гадаадад зорчих хүүхдэд үндэсний гадаад паспортод хавсаргах үнэмлэх олгоход 2 500 төгрөг;~~

[/Энэ заалтыг 2018 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

~~10.5./Энэ хэсгийг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

10.6.Гадаадын иргэн, харьяалалгүй хүнд Монгол Улсын виз, оршин суух зөвшөөрөл олгох, виз, оршин суух зөвшөөрлийн хүсэлтийг хянах, бүртгэх үйлчилгээ үзүүлэхэд доор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

[/Энэ хэсгийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

10.6.1.гадаадын иргэнд тус улсад албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл олгоход 60 000-150 000 төгрөг;

10.6.2.суралцах, мэргэжил дээшлүүлэх, дадлага, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх гадаадын иргэнд оршин суух зөвшөөрөл олгоход 12 000-30 000 төгрөг;

10.6.3.гадаадын иргэн, харьяалалгүй хүнд Монгол Улсад оршин суух үнэмлэх олгох, солиход 15 000-36 000 төгрөг;

[/Энэ заалт ад 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

10.6.4.гадаадын иргэн, харьяалалгүй хүний тус улсад албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрлийн хугацааг сунгахад 36 000-90 000 төгрөг;

10.6.5.харьяалалгүй хүнд гадаадад зорчих үнэмлэх олгох, үнэмлэхний хугацаа сунгахад 4800-12 000 төгрөг;

10.6.6.гадаадын иргэнд хувийн хэрэг хөтөлж, регистрийн дугаар олгоход 1200-3000 төгрөг;

10.6.7.гадаадын иргэн, харьяалалгүй хүний оршин суух үнэмлэхэд оршин суугаа хаягийн өөрчлөлт, бусад тэмдэглэл хийх тухай бүр 1000-2500 төгрөг;

~~10.6.8.хувийн хэрэг хөтөлж, регистрийн дугаар олгосон гадаадын иргэн, харьяалалгүй хүний баримт бичигт гадаадад эөрчсөн тэмдэглэл хийх тухай бүр 1000-2500 төгрөг;~~

[/Энэ заалтыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

10.6.9.Монгол Улсад хувийн хэргээр зорчих урилга олгоход 10 000-15 000 төгрөг;

[/Энэ заалт ад 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

10.6.10.гадаадын иргэний талаар тодорхойлолт гаргахад 1000-2500 төгрөг;

10.6.11.гадаадын иргэн оршин суух болон зорчих үнэмлэхээ алдсан, үрэгдүүлсэн, гээгдүүлсэн, хүчингүй буюу ашиглах боломжгүй болгосон тохиолдолд шинээр буюу дахин олгоход 36 000-90 000 төгрөг;

~~10.6.12.гадаадын иргэнийг бүртгэхэд 1000-2500 төгрөг;~~

[/Энэ заалтыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

10.6.13.гадаадын иргэнд визийн зөвшөөрөл олгоход /хүн тус бүрээр/ 1000-2500 төгрөг;

~~10.6.14.гадаадын иргэн, харьяалалгүй хүнд орон нутагт явахад зөвшөөрөл олгоход /хүн тус бүрээр/ 1000-2500 төгрөг;~~

[/Энэ заалтыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

10.6.15.нэг удаагийн орох виз олгоход 115 000-270 000 төгрөг;

[/Энэ заалтыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

10.6.16.хоёр удаагийн орох виз олгоход 160 000-320 000 төгрөг;

[/Энэ заалтыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

10.6.17.зургаан сарын олон удаагийн виз олгоход 210 000-450 000 төгрөг;

[/Энэ заалт ад 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

10.6.18.зургаан сараас нэг жил хүртэлх хугацаагаар олон удаагийн виз олгоход 460 000-750 000 төгрөг;

[/Энэ заалт ад 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

10.6.19.дамжин өнгөрөх нэг удаагийн виз олгоход 36 000-90 000 төгрөг;

10.6.20.дамжин өнгөрөх хоёр удаагийн виз олгоход 72 000-180 000 төгрөг;

10.6.21.дамжин өнгөрөх олон удаагийн виз олгоход 96 000-240 000 төгрөг;

~~10.6.22.хувийн хэрэг хөтөлж, регистрийн дугаар олгосон гадаадын иргэнд нэг болон хоёр удаагийн гарах орох виз олгоход 18 000-45 000 төгрөг;~~

[/Энэ заалтыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

10.6.23.нэг визэд хавсаргасан иргэдийн визийг салгах, визийг шилжүүлэн олгоход 16 000-45 000 төгрөг;

10.6.24.визийн хугацааг долоо хүртэл хоногоор сунгахад 27 000-67 500 төгрөг, дараагийн хоног тутамд 3600-9000 төгрөг;

10.6.25.визийн ангилал өөрчлөхөд 36 000-90 000 төгрөг;

10.6.26.олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газар нээн ажиллуулах зөвшөөрөл өгч, гэрчилгээ олгоход 900 000-2 250 000 төгрөг;

10.6.27.олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын зөвшөөрөл өгч, гэрчилгээний хугацааг сунгахад 360 000-900 000 төгрөг;

10.6.28.олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэлийн гэрчилгээг дахин олгоход 60 000-150 000 төгрөг;

10.6.29.Монгол Улсын харьяат болох, харьяатаас гарах, иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлтийг хянан шийдвэрлүүлэхэд 60 000-150 000 төгрөг.

10.6.30.гадаадын иргэний бүх төрлийн виз, визийн болон оршин суух зөвшөөрөл олгох хүсэлтийг хянан, энэ хуулийн

10.6.1, 10.6.2, 10.6.3, 10.6.4, 10.6.5, 10.6.6, 10.6.7, 10.6.9, 10.6.10, 10.6.11, 10.6.13, 10.6.15, 10.6.16, 10.6.17, 10.6.18, 10.6.19, 10.6.20, 10.6.21, 10.6.23, 10.6.24, 10.6.25, 10.6.26, 10.6.27, 10.6.28, 10.6.29-д заасан үйлчилгээг татгалзсан тохиолдолд тэмдэгтийн хураамжийг буцаан олгохгүй.

[/Энэ заалтыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

[/Энэ хэсгийг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

10.7.Энэ хуулийн 10.6-д заасан гадаадын иргэнд үзүүлэх үйлчилгээг яаралтай буюу хилийн боомт дээр үзүүлэх тохиолдолд хураамжийн хэмжээг хоёр дахин нэмэгдүүлэн хураана.

[/Энэ хэсгийг 2011 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

11 дүгээр зүйл.Консулын үйлчилгээ үзүүлэхэд хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

11.1.Гадаадад зорчих эрхийн бүртгэлд бүртгэхэд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

- 11.1.1.үндэсний энгийн гадаад паспорт олгоход 12 500 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;
- 11.1.2.дипломат, албан паспорт олгоход 30 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;
- 11.1.3.Монгол Улсад буцах үнэмлэх олгоход 22 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;
- 11.1.4.үндэсний гадаад паспортын хүчинтэй хугацааг сунгахад 2500 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;
- 11.1.5.хүүхдийн үнэмлэх олгоход 2000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.2.Монгол Улсад зорчих гадаадын иргэн, харьяалалгүй хүнд виз олгоход энэ хуулийн 10.6-д заасан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана.

11.3.Консулын үйлчилгээг яаралтай үзүүлэх тохиолдолд энэ хуулийн 10.6-д заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг ажлын 8 цагийн дотор бол хоёр дахин нэмэгдүүлж, амралт, баяр ёслолын өдөр бол гурав дахин нэмэгдүүлэн хураана.

11.4.Консулын нотариатчийн үүрэг гүйцэтгэгчийн үйлчилгээнд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

- 11.4.1.эд хөрөнгийн бус үнэлэх боломжгүй гэрээ, хэлцэл гэрчлэхэд 18 000-54 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;
- 11.4.2.эд хөрөнгийн бус үнэлэх боломжгүй гэрээ, хэлцэлд өөрчлөлт оруулсан, хугацаа сунгасныг гэрчлэхэд 7500-22 500 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;
- 11.4.3.эд хөрөнгө хөлслөх, түрээслэх гэрээ, дүрэм гэрчлэхэд 23 000-69 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;
- 11.4.4.Монгол Улсын газрын харилцаанд холбогдох гэрээнээс бусад хэлцэл /гэрээ, итгэмжлэл зэрэг/-ийг гэрчлэхэд 52 000-156 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;
- 11.4.5.баримт бичигт консулын баталгаа гаргахад 1500-4500 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;
- 11.4.6.баримт бичгийг болон баримт бичгийн хуулбарын үнэн зөвийг гэрчлэхэд хуудас тутмаас 1500-4500 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;
- 11.4.7.баримт бичгийн орчуулгыг гэрчлэхэд хуудас тутмаас 300-900 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;
- 11.4.8.баримт бичигт зурсан гарын үсгийг гэрчлэхэд 2500-7500 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;
- 11.4.9.гэрчлэгдсэн баримт бичгийн хуулбарыг гэрчлэхэд хуудас тутмаас 200-600 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;
- 11.4.10.үйлчлүүлэгчийн хүсэлтээр үндсэн материалыг шалгахад 7500-22 500 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;
- 11.4.11.үл хөдлөх эд хөрөнгийн холбогдолтой баримт бичгийг гэрчлэхэд баримт бичигт тусгагдсан үнийн дүнгийн 0.06 хүртэл хувиар;
- 11.4.12.үл хөдлөх эд хөрөнгийн гэрээг гэрчлэхэд нөхөр, эхнэр, хүүхэд, эцэг, эхийн хувьд гэрээний үнийн дүнгээс 0.035 хүртэл хувиар, бусад хүнд үнийн дүнгийн 0.055 хүртэл хувиар;
- 11.4.13.энэ хуулийн 11.4.1-11.4.3, 11.4.7-д зааснаас бусад гэрээ, хэлцлийг гэрчлэхэд үнийн дүнгийн 1 000 000 хүртэл төгрөгөөс 0.025 хүртэл хувиар, 1 000 000 төгрөгөөс давсан хэсгээс 0.015 хүртэл хувиар нэмэгдүүлж;
- 11.4.14.хууль тогтоомжид заасан бусад үйлчилгээ үзүүлэхэд үнийн дүнгийн 1.2 хүртэл хувиар;
- 11.4.15.хуулийн этгээдийг үүсгэн байгуулах тухай гэрээ, дүрэм гэрчлэхэд хуудас тутмаас 240-720 төгрөг буюу түүнтэй тэнцэх бусад валют;
- 11.4.16.хуулийн этгээд үүсгэн байгуулах, татан буулгах баримт бичиг гэрчлэхэд 4400-13 200 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;
- 11.4.17.хуулийн этгээд үүсгэн байгуулах, татан буулгах баримт бичигт өөрчлөлт оруулсан, хугацааг нь сунгасныг гэрчлэхэд

1100-3300 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.4.18.хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөн байгуулах эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг гэрчлэхэд 2000-6000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.4.19.аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл болон зөвшөөрөлтэй холбогдсон баримт бичиг гэрчлэхэд 20 000-60 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.4.20.өв залгамжлах эрх, гэрээслэл гэрчлэхэд 1100-3300 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.4.21.гэр бүлийн гишүүдийн дундаа хамтран болон дундаа хэсгээр өмчлөх эрхийг гэрчлэхэд 1000-2000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют.

11.5.Өв залгамжлал, гэрээслэл, гэр бүлийн гишүүдийн дундаа хамтран болон дундаа хэсгээр өмчлөх эд хөрөнгөөс оногдох хувиа өмчлөх эрх, үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэхтэй холбоотой гэрээ зэрэг тодорхой үнийн дүн, төлбөрийн хэмжээ бүхий бүх төрлийн гэрээ, хэлцлийг гэрчлэхэд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

11.5.1.1000 хүртэл ам.доллартай тэнцэх дүнтэй бол 15 000-45 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.5.2.1001-10000 ам.доллартай тэнцэх үнийн дүнтэй бол 23 000-69 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.5.3.10001-25000 ам.доллартай тэнцэх үнийн дүнтэй бол 30 000-90 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.5.4.25001-100000 ам.доллартай тэнцэх үнийн дүнтэй бол 37 000-111 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.5.5.100001-300000 ам доллартай тэнцэх үнийн дүнтэй бол 45 000-135 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.5.6.300001 болон түүнээс дээш ам.доллартай тэнцэх үнийн дүнтэй бол 60 000 -180 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.5.7.өвлүүлэгчийн нөхөр, эхнэр, эцэг, эхээс бусад хүнд өв залгамжлах эрхийн гэрчилгээ олгоход 100 000-300 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.5.8.аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ, тээврийн хэрэгслийн гэрчилгээ зэрэг үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг нотлох бүх төрлийн баримт бичгийн хуулбарыг гэрчлэхэд 7500-22 500 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют.

[/Энэ зүйлийг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

12 дугаар зүйл.Тээврийн болон өөрөө явагч хэрэгслийг бүртгэх, жолоодох зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

12.1.Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийг бүртгэх, жолоодох зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

12.1.1.автотээврийн хэрэгслийн гэрчилгээ, ашиглалтын дэвтэр олгоход 1000-2000 төгрөг;

12.1.2.автотээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх, мэргэшсэн жолоочийн үнэмлэх олгоход 1000-2000 төгрөг;

12.1.3.автотээврийн хэрэгслийн гэрчилгээ, ашиглалтын дэвтрийг алдаж үрэгдүүлэх, гээгдүүлэх, хүчингүй буюу ашиглах боломжгүй болгосноос дахин олгоход 8000-20 000 төгрөг;

12.1.4.өөрөө явагч хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх олгоход 1000-2000 төгрөг.

12.2.Автомашин, өөрөө явагч хэрэгсэл, мотоциклийн дугаар олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

12.2.1.автомашин дугаар олгоход 1000-2200 төгрөг;

12.2.2.өөрөө явагч хэрэгсэл, чиргүүлийн улсын дугаар олгоход 1000-2000 төгрөг;

12.2.3.мотоциклийн улсын дугаар олгоход 1000-2000 төгрөг;

12.2.4.автомашин, өөрөө явагч хэрэгсэл, чиргүүлийн болон мотоциклийн улсын дугаарыг алдаж үрэгдүүлэх, гээгдүүлэх, хүчингүй буюу ашиглах боломжгүй болгосноос дахин олгоход 16 000-40000 төгрөг.

12.3.Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн тээврийн хэрэгсэл өмчилж авсан бол түүнийг зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа орон нутаг дахь байгууллага бүртгэхэд 1000-2000 төгрөгийн тэмдэгтийн хураамж хураана.

12.4.Агаарын хөлөг болон усан онгоцыг бүртгэх, агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ, усан /хөлөг/ онгоцыг бүртгэхэд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

12.4.1.Монгол Улсын иргэн, тус улсад байнга оршин суугаа харьяалалгүй хүн, хуулийн этгээдийн өмчлөлд байгаа агаарын хөлгийг улсын бүртгэлд бүртгэж, үндэсний таних тэмдэг, бүртгэлийн гэрчилгээ олгоход 17 600-44 000 төгрөг;

12.4.2.гадаадын хуулийн этгээд, гадаадын иргэн, харьяалалгүй хүний өмчлөлд байгаа агаарын хөлгийг Монгол Улсын иргэний агаарын тээвэрт ашиглахаар гэрээ байгуулсан нөхцөлд улсын бүртгэлд бүртгэж үндэсний таних тэмдэг, бүртгэлийн гэрчилгээ

15 дугаар зүйл.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээнд хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

15.1.Хуулийн этгээдийн эрх, үүрэг үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болохтой холбоотой бүртгэлийн үйл ажиллагаанд доор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

- 15.1.1.хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэхэд 44 000 төгрөг;
- 15.1.2.хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрыг улсын бүртгэлд бүртгэхэд 20 000 төгрөг;
- 15.1.3.хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэхэд 10 000 төгрөг;
- 15.1.4.улсын бүртгэлийн мэдээллээс лавлагаа олгоход 5 000 төгрөг.

15.2.Шашны байгууллагыг улсын бүртгэлд бүртгэхэд доор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

[/Энэ хэсэгт 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

- 15.2.1.улс төрийн намыг бүртгэж, гэрчилгээ олгоход 60 000-150 000 төгрөг;
[/Энэ заалтыг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд т ооцсон./](#)
- 15.2.2.улс төрийн намын нэр сольсныг бүртгэхэд 20 000-50 000 төгрөг;
[/Энэ заалтыг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд т ооцсон./](#)
- 15.2.3.шашны байгууллагыг бүртгэхэд 200 000 төгрөг;
- 15.2.4.шашны байгууллагын мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэхэд 40 000 төгрөг;
- 15.2.5.шашны байгууллагын гэрчилгээний хугацаа сунгахад 80 000 төгрөг.

15.3.Гадаадын байгууллага, түүний салбар, төлөөлөгчийн газар болон гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэхэд доор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

- 15.3.1.гадаадын хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрыг бүртгэхэд 1 100 000 төгрөг;
- 15.3.2.гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэхэд 750 000 төгрөг;
- 15.3.3.гадаадын хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрын баримт бичигт оруулсан өөрчлөлтийг бүртгэхэд 35 000 төгрөг;
- 15.3.4.гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн баримт бичигт оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэхэд 40 000 төгрөг;
- 15.3.5.гадаадын хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа явуулах хугацаа сунгахад 750 000 төгрөг;
- 15.3.6.гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн үйл ажиллагаа явуулах хугацаа сунгахад 75 000 төгрөг;
- 15.3.7.гадаадын хөрөнгө оруулалттай банкны төлөөлөгчийн газрыг бүртгүүлэхэд 1 800 000 төгрөг.
[/Энэ зүйлийг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан ба 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

16 дугаар зүйл.Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын байгууллага, түүний төлөөлөгчийн газар ажиллуулах, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулах зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

16.1.Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд байгуулах, хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар ажиллуулах зөвшөөрөл олгоход доор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

- 16.1.1.салбар, төлөөлөгчийн газар, нэгж ажиллуулахад 440 000-1 100 000 төгрөг;
- 16.1.2.салбар, төлөөлөгчийн газрын ажиллах хугацааг сунгахад 300 000-750 000 төгрөг;
- 16.1.3.гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулахад 300 000-750 000 төгрөг;
- 16.1.4.гэрчилгээний хугацааг сунгахад 30 000-75 000 төгрөг;
- 16.1.5.гэрчилгээг сольж олгоход анх олгоход хураасан тэмдэгтийн хураамж дээр 1.5 дахин нэмэгдүүлсэн хэмжээгээр;
- 16.1.6.гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын гэрээ, дүрэмд орсон өөрчлөлтийг бүртгэхэд 14 000-35 000 төгрөг;
- 16.1.7.гадаадын хөрөнгө оруулалттай банк байгуулах зөвшөөрөл олгоход 1 120 000-2 800 000 төгрөг;
- 16.1.8.гадаадын хөрөнгө оруулалттай банкны салбар, төлөөлөгчийн газар ажиллуулах зөвшөөрөл олгоход 720 000-1 800 000 төгрөг.

[/Энэ зүйлийг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

Хураамжийн хэмжээг тооцох нэгж	Хураамжийн доод Хэмжээ /төгрөгөөр/	Хураамжийн дээд Хэмжээ /төгрөгөөр/
6м ³ хүртэл	1000	3000
6-10м ³ хүртэл	1500	4500
10-20м ³ хүртэл	2000	6000
20-60м ³ хүртэл	5000	15000

35.5.2.ойгоос хэрэглээний мод бэлтгэх эрхийн бичиг олгоход:

Хураамжийн хэмжээг тооцох нэгж	Хураамжийн доод хэмжээ /төгрөгөөр/	Хураамжийн дээд хэмжээ /төгрөгөөр/
8м ³ - # хүртэл	1500	4500
8-10м ³ - # хүртэл	2000	6000
10-20м ³ - # хүртэл	3500	10500
20-30м ³ - # хүртэл	5000	15000

35.5.3.ойгоос түлээ бэлтгэх эрхийн бичиг олгоход:

Хураамжийн хэмжээг тооцох нэгж	Хураамжийн доод хэмжээ /төгрөгөөр/	Хураамжийн дээд хэмжээ /төгрөгөөр/
0-10м ³ - #	1000	3000
10-20м ³ - #	1200	3600
20-30м ³ - #	1500	4500

35.5.4.арчилгаа, цэвэрлэгээний журмаар бэлтгэсэн модонд гарал үүслийн гэрчилгээ олгоход 0-10 куб метр бол 1000-2000 төгрөг, 10 куб метрээс дээш бол 1000-2000 төгрөг дээр 10-аас дээш сийрэг куб метр тутамд 100-150 төгрөг нэмж

35.5.5.ойгоос бэлтгэсэн гуалин, шургааг, дүнс, зүсмэл материалыг өөр аймаг, сум, хот, суурингийн хооронд тээвэрлэх, худалдах, мод, модон материалын гарал үүслийн гэрчилгээ олгоход 0-10 куб метр бол 1000-2000 төгрөг, 10 куб метрээс дээш бол 1000-2000 төгрөг дээр 10-аас дээш куб метр тутамд 100-150 төгрөг нэмж.

35.6.Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь доор дурдсан төлбөр төлнө:

35.6.1.түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр хайгуулын талбайн гектар тутамд эхний жилд 200 төгрөг, хоёр дахь жилд 400 төгрөг, гурав дахь жилд 600 төгрөг, дөрвөөс тав дахь жилд тус бүр 2000 төгрөг;

[/Энэ заалтыг 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

35.6.2.түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр нь тухайн тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн 0-20 гектар тутамд 5000 төгрөг, 30 гектар хүртэл 8000 төгрөг, 50 гектар хүртэл 10000 төгрөг, 100 гектар хүртэл 15000 төгрөг, 200 гектараас дээш 20000 төгрөг.

[/Энэ хэсгийг 2014 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

[/Энэ зүйлийг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

36 дугаар зүйл.Шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын патент, барааны тэмдэг, газар зүйн заалтад гэрчилгээ олгох, зохиогчийн эрхийн бүтээлийг бүртгэж гэрчилгээ олгох, патентыг хүчинтэй байлгах, барааны тэмдгийн гэрчилгээний хүчинтэй байх хугацааг сунгах, лицензийн гэрээг бүртгэхэд хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

36.1.Шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын патент, барааны тэмдэг, газар зүйн заалтын гэрчилгээ олгох, зохиогчийн эрхийн бүтээл болон зохиогчийн эрхэд хамаарах эрхийн бүтээлийг бүртгэж гэрчилгээ олгоход доор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

36.1.1.шинэ бүтээлийн патент олгоход 25 000 төгрөг;

36.1.2.бүтээгдэхүүний загварын патент олгоход 25 000 төгрөг;

36.1.3.ашигтай загварын патент олгоход 25 000 төгрөг;

36.1.4.барааны тэмдгийн гэрчилгээ олгоход 25 000 төгрөг;

36.1.5.газар зүйн заалтын гэрчилгээ олгоход 25 000 төгрөг;

36.1.6.зохиогчийн эрхийн бүтээл болон зохиогчийн эрхэд хамаарах эрхийн бүтээлийг улсын бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгоход 25 000 төгрөг.

36.2.Шинэ бүтээлийн патентыг хүчинтэй байлгахад доор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

36.2.1.эхний 5 жилд 40 000 төгрөг;

36.2.2.6-10 жилд 60 000 төгрөг;

36.2.3.11-15 жилд 80 000 төгрөг;

36.2.4.16-20 жилд 120 000 төгрөг.

36.3.Бүтээгдэхүүний загварын патентыг хүчинтэй байлгахад доор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

36.3.1.эхний 5 жилд 40 000 төгрөг;

36.3.2.6-10 жилд 80 000 төгрөг;

36.3.3.11-15 жилд 120 000 төгрөг.

36.4.Барааны тэмдгийн гэрчилгээний хүчинтэй байх хугацааг 10 жилээр сунгахад 40 000 төгрөгийн тэмдэгтийн хураамж хураана.

36.5.Патент олгосон шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар, барааны тэмдгийг бусдад ашиглуулах болон технологи дамжуулах лицензийн гэрээг бүртгэхэд 20 000 төгрөгийн тэмдэгтийн хураамж хураана.

[/Энэ зүйлийг 2021 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

[/Энэ зүйлийг 2011 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

37 дугаар зүйл.Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллах зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

37.1.Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллах иргэн, хуулийн этгээдийг шалгаруулж, тусгай зөвшөөрөл олгоход 40 000-100 000 төгрөгийн тэмдэгтийн хураамж хураана.

[/Энэ хэсэг т 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

[/Энэ зүйлийг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

38 дугаар зүйл.Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээнд хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

38.1.Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэл хийх үйлчилгээнд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

38.1.1.шинээр бий болсон үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг түүний шинээр бий болсныг нотлох баримт бичгийг үндэслэн бүртгэхэд тухайн үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн бүртгэлд тусгах үнийн 0.01 хувиар;

~~38.1.2./Энэ заалтыг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

~~38.1.3./Энэ заалтыг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

~~38.1.4./Энэ заалтыг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

~~38.1.5./Энэ заалтыг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

~~38.1.6./Энэ заалтыг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

~~38.1.7./Энэ заал туг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

~~38.1.8./Энэ заал туг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

~~38.1.9./Энэ заал туг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

~~38.1.10./Энэ заал туг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

~~38.1.11./Энэ заал туг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

~~38.1.12./Энэ заал туг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

~~38.1.13./Энэ заал туг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

~~38.1.14./Энэ заал туг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

~~38.1.15./Энэ заал туг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

~~38.1.16./Энэ заал туг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

~~38.1.17./Энэ заал туг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

~~38.1.18./Энэ заал туг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

~~38.1.19./Энэ заал туг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

~~38.1.20./Энэ заал туг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

~~38.1.21./Энэ заал туг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

39 дүгээр зүйл.Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах зөвшөөрөл олгох, газрын хэвлийг олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

39.1.Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах зөвшөөрөл олгох, газрын хэвлийг олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

39.1.1.иргэнд газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээг шинээр олгоход нийслэлд 20 000 төгрөг, аймгийн төвийн сум, нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүрэгт 10 000 төгрөг, бусад суманд 6 000 төгрөг;

39.1.2.аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээг шинээр олгоход нийслэлд 70 000 төгрөг, аймгийн төвийн сум, нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүрэгт 20 000 төгрөг, бусад суманд 10 000 төгрөг;

39.1.3.иргэн газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэхэд нийслэлд 20 000 төгрөг, аймгийн төвийн сум, нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүрэгт 10 000 төгрөг, бусад суманд 6 000 төгрөг;

39.1.4.аж ахуйн нэгж, байгууллага газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэхэд нийслэлд 70 000 төгрөг, аймгийн төвийн сум, нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүрэгт 20 000 төгрөг, бусад суманд 10 000 төгрөг;

39.1.5.газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний хугацааг сунгахад иргэнээс 6 000 төгрөг, аж ахуйн нэгж, байгууллагаас 12 000 төгрөг;

39.1.6.газрын дуудлага худалдаа, төсөл шалгаруулах баримт бичиг хүлээн авахад 12 500 төгрөг;

39.1.7.геологийн судалгаа хийх зориулалтаар ашиглуулахаар газрын хэвлийг олгоход 70 000 төгрөг;

39.1.8.ашигт малтмал олборлоход зориулан газрын хэвлийг олгоход
1 000 000 төгрөг;

39.1.9.ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар ашиглуулахаар газрын хэвлийг олгоход 70 000 төгрөг;

39.1.10.Улсын Их Хурлаас гадаад улс, олон улсын байгууллага, гадаадын хуулийн этгээдэд газрыг тодорхой хугацаагаар түрээс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр ашиглуулахаар шийдвэрлэж, зөвшөөрөл олгоход м2 тутамд 2 000 төгрөг;
[/Энэ заал тад 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

39.1.11.дархан цаазат газрын болон байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс, байгалийн нөөц газар, дурсгалт газраас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар ашиглуулах тухай шийдвэрийг хамгаалалтын захиргаа болон сум, дүүргийн Засаг даргын саналыг үндэслэн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас шийдвэр гаргаж зөвшөөрөл

олгоход нийслэлд м² тутамд 500 төгрөг, аймагт м² тутамд 100 төгрөг;

[/Энэ заалт ад 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

39.1.12.газар эзэмшигч нь эрхийн гэрчилгээг Иргэний хуульд нийцүүлэн барьцаалсан тухай сумын газрын даамал, аймаг, нийслэл, дүүргийн газрын албанд бүртгүүлж, эрхийн гэрчилгээнд барьцаалсан тухай тэмдэглэл хийлгэхэд 10 000 төгрөг;

39.1.13.иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчны тэнцвэрт байдал, хүн амын эрүүл мэнд, мал, амьтан, агаар, ой, ус, ургамалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй барилга байгууламж барих, тоног төхөөрөмж байршуулах, үйлдвэрийн хаягдал, бохир ус, хортой болон бусад бодисыг газрын дор хадгалах, булах зөвшөөрөл олгоход 950 000 төгрөг.

40 дүгээр зүйл.Баримт бичиг баталгаажуулж, "Апостиль" гэрчилгээ олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

40.1.Гадаадын албан ёсны баримт бичгийг баталгаажуулах шаардлагыг халах тухай конвенцийн гишүүн улсад хэрэглэгдэх дотоодын албан ёсны баримт бичгийг төрийн захиргааны төв байгууллагаас баталгаажуулж, "Апостиль" гэрчилгээ олгоход 8000-20 000 төгрөгийн хураамж хураана.

[/Энэ хэсэгт 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

40¹ дүгээр зүйл.Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийг цахим мэдээллийн санд бүртгүүлэх, бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлийн хугацааг сунгах болон лавлагаа авахад хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

40¹.1.Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийг цахим мэдээллийн санд бүртгүүлэх, бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлийн хугацааг сунгах болон лавлагаа авахад доор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

40¹.1.1.барьцааны мэдэгдлийг цахим мэдээллийн санд бүртгүүлэхэд 20000 төгрөг;

40¹.1.2.барьцааны мэдэгдэлд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг бүртгэх, бүртгэлийн хугацааг сунгахад 10000 төгрөг;

40¹.1.3.цахим мэдээллийн сангаас лавлагаа олгоход 5000 төгрөг.

[/Энэ зүйлийг 2015 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

40² дугаар зүйл.Таримал ургамлын сортын бүтээгчийн эрх олгох, эрхийг хүчинтэй байлгахад хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

[/Энэ зүйлийг 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

40².1.Таримал ургамлын сортын бүтээгчийн эрх олгох, эрхийг хүчинтэй байлгахад доор дурдсан хэмжээгээр хураамж хураана:

40².1.1.сортын бүтээгчийн эрх олгоход 20 000 төгрөг;

40².1.2.сортын бүтээгчийн эрхийг хүчинтэй байлгахад жил бүр 60 000 төгрөг.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

41 дүгээр зүйл.Тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх, хөнгөлөх

41.1.Шүүхэд гаргасан дараахь нэхэмжлэлийг тэмдэгтийн хураамжаас чөлөөлнө:

41.1.1.тэтгэвэр, тэтгэмжийн талаар гаргасан нэхэмжлэл;

41.1.2.патент, зохиогчийн эрхтэй холбогдсон нэхэмжлэл;

41.1.3.төсвийн байгууллагын нэхэмжлэл;

41.1.4.төсөвт төлөх албан татвар, хураамж, төлбөр, торгууль, хүү, алдангийг төлүүлэх талаар гаргасан нэхэмжлэл;

41.1.5.гомдлоор авч хэлэлцэх хэргийн нэхэмжлэл;

41.1.6.шүүхийн зардал төлөх хөрөнгөгүйн улмаас шүүхийн шийдвэр, магадлалаар шүүхийн зардал төлөхөөс чөлөөлөгдсөн иргэний нэхэмжлэл;

41.1.7.гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгуулахаар гаргасан нэхэмжлэл;

41.1.8.цэргийн алба хаагчаас цэргийн үүрэг гүйцэтгэхтэй холбогдон гаргасан өргөдөл, нэхэмжлэл;

[/Энэ заалт ад 2016 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)